



МЭДЭГДЭЛ

ТҮРГЭН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧ

.....ТАНАА

Цөөн, энгийн нэр төрлийн, хадгалах, худалдахад онцгой нөхцөл, горим шаарддаггүй барааг зөвшөөрөгдсөн байршилд, суурин бус байгууламжид худалдахыг түргэн үйлчилгээний цэг гэж холбогдох хууль тогтоомжид заасан байна.

1. Түргэн үйлчилгээний цэгийн үйл ажиллагаа эрхлэгч нар дотоод хяналтыг байнгын тавьж, хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлтийн нөхцлөөс үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах шаардлагуудыг ханган ажиллахыг мэдэгдэж байна. Үүнд:

1.1. Түргэн үйлчилгээний цэг нь галын аюулгүй байдлын тухай хуулийн холбогдох заалтыг хангасан;

1.2. Дүүргийн худалдаа, үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллах гэрээнд заасны дагуух өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, тохижуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх;

1.3. Зориулалтын бус байранд буюу түргэн үйлчилгээний цэгт инженерийн төвлөрсөн болон хэсгийн шугам сүлжээнд холбогдоогүй, эрүүл ахуй ариун цэврийн шаардлага хангахгүй нөхцөлд худалдаалах үйл ажиллагааг явуулснаар хүнсний бүтээгдэхүүн хөлдөх, зайрмагтах гэх мэт физик өөрчлөлтөд орж, чанар, аюулгүй байдлаа алдах боломжийг бүрдүүлэхгүй байх;

1.4. Түргэн үйлчилгээний цэг нь гар угаах хэрэгсэлтэй байхаас гадна хүрэлцэхүйц хэмжээний хөргөгч, хөлдөөгчтэй байх;

1.5. Цөөн нэр төрлийн, хадгалах болон худалдаалахад онцгой нөхцөл, горим шаарддаггүй хүнсний бүтээгдэхүүнийг худалдах;

1.6. Агаарын чанарыг сайжруулах зорилгоор 1-4 дүгээр бүсэд байршилтай түргэн үйлчилгээний цэгүүд нь түүхий нүүрсийг дулааны эх үүсвэр болгон ашиглахгүйгээс гадна зүүхгүй байх;

1.7. Хүнсний бүтээгдэхүүнтэй харьцаж буй ажилчид эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх шинжилгээнд заасан хугацаанд тогтмол хамруулах;

2. Түргэн үйлчилгээний цэгт худалдаалахад хориглох зүйлс:

2.1. Түргэн гэмтэх бүтээгдэхүүн /болсон өндөг, пирошки, гамбургер, ороомог, зайдас, хиам, хуушуур, кембаб гэх мэт/ -ийг тасалгааны температурт буюу $+10 + 20^{\circ}\text{C}$ /-д ил задгай байдлаар худалдахгүй байх;

2.2. Хуулиар хориглосон бүтээгдэхүүн /согтууруулах ундаа, тамхи, хар тамхи, хүн, малын эм, эмнэлгийн хэрэгсэл гэх мэт/-ийг худалдахгүй байх;

2.3. Хүнсний будаг, амт үнэр оруулагч орсон хүчиллэг ихтэй чихэр, гаа, төрөл бүрийн тоглоомтой чихэр, хатаасан жимс гэх мэт ширхэгээр худалдаалахгүй байх;

2.4. Хүнсний эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангаагүй хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, буруу шошголсон, гарал үүсэл нь тодорхойгүй, хуурамч түүхий эд, бүтээгдэхүүн, хүнсний зориулалтын бус сав баглаа боодолтой бүтээгдэхүүн худалдахгүй болон хадгалахгүй байх;

2.5. Нөөшилсөн бүтээгдэхүүний лааз хонхойсон, зэвэрсэн битүүмжлэл алдагдсан, төвийлт үүссэн бүтээгдэхүүнийг худалдахгүй байх;

3. Дээрх шаардлагуудыг хангаагүй тохиолдолд дараах хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх болно. Үүнд:

3.1. Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтын дагуу тухайн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний /720,0-1,200/ төгрөгөөр торгох;

3.2. Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй, түүнчлэн хуурамч болон шошгод тавих шаардлага хангаагүй, хүнсний бүтээгдэхүүнийг буцаан болон татаж аваагүй тохиолдолд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын дагуу тухайн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг наймаас арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний /1920,0-2400,0/ төгрөгөөр торгох;

3.3 Хэрэглэж дуусах хугацаа нь хэтэрсэн хүнсний бүтээгдэхүүнийг худалдан борлуулсан, уг хугацааг өөрчлөн засварласан бол Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6 дахь заалтын дагуу тухайн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний /1440,0-1920,0/ төгрөгөөр торгох;

3.4 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдаагүй ажилтан худалдаа, үйлчилгээ явуулсан тохиолдолд Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалтын дагуу нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин тав дахин нэмэгдүүлсэн тэнцэх хэмжээний /8400,0/ төгрөгөөр торгох;

3.5 Зөвшөөрөгдөөгүй цэгт тамхи худалдсан бол Тамхины хяналтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтын дагуу иргэнийг 50,000 төгрөгөөр торгож, тамхи болон хууль бусаар олсон орлогыг хурааж;

3.6 Тусгай зөвшөөрөлгүйгээр согтууруулах ундааг худалдаж, түүгээр үйлчилсэн бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтын дагуу хууль бусаар олсон орлогыг хурааж, гэм буруутай иргэнийг 20,0-50,0 төгрөгөөр тус тус торгоно.

НИЙСЛЭЛИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР